

# НИЙГМИЙН АЖИЛ



06/2022 – 13

**Ч.ТАМИР**

Угсаатны нийгмийн ажил

**С.ТУЯА, КИМ ЖЭ СОНЬ**

Нийгмийн ажлын ёс зүй дэх хүний эрхийн асуудал

**Г.ЗОЛЖАРГАЛАН, О.ЭНХЗУЛ, М.СУГАРМАА**

Эрүүл мэндийн нийгмийн ажлын үйлчилгээг эрүүл  
мэндийн тогтолцооны ангиллаар харьцуулсан тойм  
судалгаа



НИЙГМИЙН АЖЛЫН ОНОЛ, ПРАКТИК, СУДАЛГААНЫ АСУУДЛУУД



# ЭРҮҮЛ МЭНДИЙН НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦООНЫ АНГИЛЛААР ХАРЬЦУУЛСАН ТОЙМ СУДАЛГАА

## Comparing health social work service according to health care system classification

Г.Золжаргалан, АШУУИС, НЭМС-ийн багш, магистр  
ORCID: 0000-0003-0124-320X

О.Энхзул, АШУУИС, НЭМС-ийн төгсөгч, бакалавр  
ORCID: 0000-0001-6104-3395

М.Сугармаа, АШУУИС, НЭМС-ийн багш, доктор  
ORCID: 0000-0003-3057-4526

### Abstract

This study compared legal framework, financial source, and licensure of health social work practice in eight different countries. We used framework analysis according to health care system classification developed by Milton Roemer.

### Keywords

Social work practice, health care system

### Оршил

19-р зуунд Европт хотжилтоос үүдсэн ядуурал, нийтийг хамарсан өвчлөл, орон гэргүй хүмүүс зэрэг нийгмийн асуудлууд бий болжээ. Сүм хийдэд түшиглэн шийдвэрлэгдэж байсан эдгээр асуудлыг нэг удаагийн тусламж, дэмжлэгээс илүүтэйгээр тогтвортой үр дүнд хүргэх үйлчилгээ үзүүлэх байдлаар шийдвэрлэхийг зорьсон нь нийгмийн ажил мэргэжил үүсэхэд нөлөөлжээ (Энхтуяа.С, Олончимэг.Д, Оюут-Эрдэнэ.Н, 2008). 1900 оны үед Лондон, Амстердам, Нью-Йорк, Берлин зэрэг хотуудад нийгмийн ажлын сургуулиуд бараг нэгэн зэрэг байгуулагдсан нь мэргэжлийн байр, сууриа бэхжүүлэх эхний үндэс болсон бөгөөд цаашид мэргэжлийн онол, арга зүйг боловсруулан хөгжүүлэх эхлэл болжээ (Түмэннаст.Г, 2017). Ийнхүү нийгмийн ажил мэргэжил хөгжихдөө шууд практик болон шууд бус практик гэсэн хоёр үндсэн чиглэлд үйлчилгээгээ үзүүлэх болсон бөгөөд эдүгээ нийгмийн ажил мэргэжил нь дэлхий дахинд эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсрол зэрэг олон салбарт хүн төвтэй тусламж үйлчилгээг хүргэхэд чухал мэргэжилтнээр хүлээн зөвшөөрөгдсөн.

Монгол улсад нийгмийн ажил мэргэжил үүсэхэд 1990 онд тохиолдсон улс төр, эдийн засгийн огцом өөрчлөлтийг даган бий болсон нийгмийн асуудлууд тэр дундаа хараа, хяналтгүй хүүхдийн асуудал чухал нөлөө үзүүлжээ. Мөн их сургуулиудын өөрчлөлт, шинэчлэлт ч шинэ тутам хөгжиж байгаа мэргэжил болох нийгмийн ажил мэргэжил үүсэхэд нөлөөлжээ (Тамир.Ч, 2021; Энхтуяа.С, Олончимэг.Д, Оюут-Эрдэнэ.Н, 2008). Эрүүл мэндийн нийгмийн ажилтныг 2003 онд Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуульд (түхайн үеийн нэрээр) бэлтгэж эхэлсэн. 2022 оны байдлаар 15 удаагийн төгсөлтөөр 300 орчим эрүүл мэндийн нийгмийн ажилтныг бэлтгэсэн байна.

1997 онд АНУ, Англи, Орос, Хятад улсаас нийгмийн ажлын багш, эрдэмтдийг урьж нийгмийн ажлын онол, арга зүйн анхны олон улсын сургалт, семинар зохион байгуулсан бөгөөд тус семинараас Монгол улсад нийгмийн хөгжлийн чиг хандлагатай нийгмийн ажлыг хөгжүүлэх нь зүйтэй гэж тодорхойлжээ. Гэвч нийгмийн ажилтнуудын дунд энэхүү үзэл баримтлалын талаар нэгдсэн ойлголт төлөвшөөгүй, нийгмийн ажлын сургалтын хөтөлбөрт хөгжилд чиглэсэн нийгмийн

ажлын чиг хандлагын талаар агуулга, арга зүй бага тусгагдсан байгааг 2008 оны судалгаанд онцолсон байна (Энхтуяа.С, Олончимэг.Д, Оюут-Эрдэнэ.Н, 2008). Түүнчлэн нийгмийн ажлын хөтөлбөрүүдийг харьцуулсан судалгааны үр дүнгээс харахад Монголын нийгмийн ажлын хөтөлбөрийн агуулга баруун төвтэй, глобал нийгмийн ажлын нөлөө хүчтэй, орон нутаг, үндэсний онцлогийг тусгасан нийгмийн ажил анхнаасаа бага байсан бөгөөд нийгмийн ажлын монгол контент бүрэлдэж чадаагүй байгаа гэжээ (Тамир.Ч, 2021)

Монгол улсад нийгмийн ажил мэргэжил үүссэн болон өнөөг хүртэл хөгжиж ирсэн түүхээс харвал бид олон ахиц, дэвшил, амжилтыг гаргаж боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хууль сахиулах зэрэг салбарт нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлж байна. Хэдий тийм ч нийгмийн ажил мэргэжлийн талаарх ойлголт олон нийтийн дунд зөрүүтэй, нийгмийн ажилтныг ажиллуулахад салбар бүрд ялгаатай бодлого хэрэгжиж байна.

### Зорилго

Улс орнуудын эрүүл мэндийн нийгмийн ажлын үйлчилгээний онцлогийг эрүүл мэндийн тогтолцоогоор харьцуулан судлах

### Материал ба арга зүй

Эрүүл мэндийн нийгмийн ажлын үйлчилгээг улс орнуудын эрүүл мэндийн тогтолцоогоор харьцуулахдаа баримтын судалгааны аргыг ашигласан. Ингэхдээ эрүүл мэндийн нийгмийн ажлын үйлчилгээг зохицуулж буй эрх зүйн орчин, лицензжүүлэлт болон эрүүл мэндийн салбар дахь нийгмийн ажлын үйлчилгээний санхүүжилт гэсэн агуулгаар шинжлэв. Судалгаанд хамрагдах улс орнуудыг сонгохдоо судлаач Ромерийн (1993) боловсруулсан эрүүл мэндийн тогтолцооны ангиллыг ашиглав. Энэхүү ангиллаар дэлхийн улс орнуудын эрүүл мэндийн тогтолцоог зах зээлийн, төгс иж бүрдэлт, нийгмийн хамгааллын, болон хуучин социалист гэж бүлэглэдэг ба энэ нь эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлдэг 5 элемент болох эрүүл мэндийн төлөвлөлт, удирдлага, зохицуулалт, хууль эрх зүй болон эрүүл мэндийн үйлчилгээг хүргэх тогтолцоонд үндэслэжээ (Roemer, 1993; Bourque & Farrah, 2021; Наранчимэг.Н,

Увш.П, Волгин.Н.А, 2009). Бид уг ангиллын дагуу нийт 8 улсыг сонгов. Ангилал бүрд эдийн засгийн хувьд

хөгжингүй болон хөгжиж байгаа тус бүр нэг багтаав.



Зураг 1: Судалгаанд харьцуулсан улс орнууд<sup>1</sup>

Судалгааны мэдээллийг 2022 оны 1-3 сард EBSCO мэдээллийн сангаас Англи хэл дээр хэвлэгдсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, мөн Монгол болон Англи хэл дээр хэвлэгдсэн нийгмийн ажлын сурах бичиг, сонгон авсан улс орнуудын болон олон улсын нийгмийн ажлын байгууллагын албан ёсны веб хуудас зэрэг эх сурвалжаас цуглуулж, фрэмворк матрицын аргыг ашиглан агуулгын шинжилгээ хийв.


### Үр дүн

Бидний судалгааны эхний харьцуулалт нь эрүүл мэндийн салбар дахь нийгмийн ажлын үйлчилгээний санхүүжилт байв. Судлаач Ромерийн ангиллаар харьцуулан харахад зах зээлийн тогтолцоот АНУ-д эрүүл мэндийн үйлчилгээ нь хувийн даатгал мөн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, орлого багатай иргэдэд чиглэсэн улсын хөтөлбөрөөс санхүүжиж байна (DiNitto, 2011). Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилт нь үйлчилгээ үзүүлсэн тоогоор даатгалаас санхүүждэг ба хувийн эмнэлэг, эмч нарын оролцоо тусламж үйлчилгээг хүргэхэд их байна. Жишээ нь ахмад настнуудад зориулсан Мэдикэйр (Medicare) хөтөлбөр нь эмнэлгийн даатгал, эрүүл мэндийн даатгал, эмийн даатгал гэсэн гурван төрөлтэй. Энэ хөтөлбөрийн хүрээнд ахмад настнууд эмнэлэг, асрамжийн газар, гэрийн үйлчилгээ, мөн тэргэнцэр зэрэг туслах хэрэгсэл, жороор олгох эмийг даатгалаараа худалдан авах боломжтой. Тус хөтөлбөр нь нийгмийн даатгалын хуулийн дагуу хөдөлмөр эрхэлж байгаа хүн бүрийн сарын цалингаас татвар суутгах замаар бүрдэх ба үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагууд энэхүү хөтөлбөрөөс үйлчилгээний санхүүжилтээ нэхэмжлэн авдаг. АНУ-д сэтгэцийн эрүүл мэнд, мансуурах эмгэг, болон зан үйлийг өөрчлөх үйлчилгээ, эмчилгээ нь даатгалаас санхүүжих үйлчилгээний төрөлд багтдаг (US Department of Health and Human Services, 2021). Ингэснээр эрүүл мэндийн нийгмийн ажлын үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр нэмэгдэж байна. Түүнчлэн эрүүл мэндийн үйлчилгээг санхүүжүүлж буй хөтөлбөрүүдэд хамрагдахын тулд үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь үйлчлүүлэгч төвтэй үнэлгээг хийж, үйлчилгээ хүргэх цогц

төлөвлөгөөтэй байхыг шаардаж байгаа нь нийгмийн ажлалтны хэрэгцээг бий болгож байна.

Харин Англи, Израйл зэрэг улсуудад эрүүл мэндийн болон гэрийн тусламж үйлчилгээ нь татвараас бусад даатгалаас санхүүждэг бөгөөд үүнд хүн амын нэг хувь хамрагдаж чаддаг. Эдгээр улсууд нь төс бүрдэлт эрүүл мэндийн тогтолцоонд багтах бөгөөд эрүүл мэндийн тогтолцоо нь засгийн газрын бүрэн хариуцаж байдаг онцлогтой. Түүнчлэн даатгал нь амбулатор бүсийн, орон нутаг дахь нийгмийн эрүүл мэнд болон их сургуулийн эмнэлгийн гэсэн дөрвөн хэд бөгөөд хүн амын тооноос шалтгаалан улсаас өөр төсөв болон бүсийн зөвлөлөөс баталсан цалингуу санхүүждэг (Gehlert & Browne, 2019; National Health System, 2022). Иргэд орлогын түвшингээсээ шалтгаан зарим үйлчилгээг өөрсдөө төлдөг ба орлогоо тохиолдолд улсаас санхүүжүүлдэг. Түүнчлэн төлбөргүй авах тусламж үйлчилгээнд хэвтсэний дараах тусламж, хөгжлийн бэрхшээлтэй зориулсан тусламж зэрэг үйлчилгээ багтдаг бөгөөд эдгээр үйлчилгээг авахад нийгмийн ажилтнууд оролцож байна (National Health Services).

ОХУ, Польш, Монгол зэрэг улсуудад эрүүл мэндийн салбарт үзүүлж байгаа нийгмийн ажлын үйлчилгээ даатгалаас санхүүжүүлдэггүй бөгөөд нийгмийн ажил цалинд тулгуурлаж байна (Balogov & Pochter, 2015; Borodkina, 2015). Эндээс харвал эрүүл мэндийн ажил дахь нийгмийн ажлын үйлчилгээ нь нэг талаас эрүүл мэндийн даатгал, нөгөө талаас төрөөс санхүүжүүлж хөтөлбөрүүд гэсэн хоёр урсгалтай байна бөгөөд үйлчилгээг санхүүжүүлж байгаа төрийн болон хөтөлбөрүүд ч эрүүл мэндийн салбар дахь нийгмийн ажлын үйлчилгээний санхүүжилтэд чухал оролцож байна.



Зураг 2: Эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилтийн онцлогууд

Эрүүл мэндийн тогтолцоог зах зээлийн зарчимд нийцүүлэх сонирхол нэлээд газар авч байгаа өнөө цаг үед

үйлчлүүлэгчээс гарах төлбөр их байх эсвэл даатгалд хамрагдаж чадахгүй хүн амд тусламж, үйлчилгээг хэрхэн хүргэх асуудлыг тунгаан цэгнэх шаардлагатайг зарим судлаачид онцолж байна (Bourque & Farrah, 2021). Мөн эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний салбарын хэрэглэгчид ихэвчлэн нэг учир санхүүжилтийг нэгтгэх асуудлыг авч үзэж байна (Lanford, Petiwala, & Landers, 2021). Нөгөө талаас Польш улсад нийгмийн ажилтны цалин бага боловч ажлын ачаалал их байдаг тул ажлаас халшрах, мэргэжлийн үйлчилгээг хүргэхэд бэрхшээлтэй байх, нийгэмд тухайн мэргэжлийн нэр хүнд алдагдах зэрэг асуудлууд тулгарч байна (Balogovb & Pachner, 2021).

Дараагийн бидний судалсан агуулга бол эрүүл мэндийн нийгмийн ажлын үйлчилгээг зохицуулсан хууль, эрх зүйн орчин байв. Нийгмийн ажлыг зохицуулж байгаа хууль эрх зүйн тогтолцоо нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл буюу лицензжүүлэлт, мэргэжилтэн бэлтгэх тогтолцоотой хамааралтай байгаа дүр зураг улс орнуудад ажиглагдаж байна. Тухайлбал, АНУ болон Англи зэрэг улсуудад нийгмийн ажилтнууд магадлан гтэмжлэгдсэн хөтөлбөр бүхий их сургуульд суралцаж мэргэжил эзэмшсэний дараа лицензийн шалгалт өгөх эсвэл нийгмийн ажилтнаар бүртгүүлэх шалгууртай байна. Ингэснээр шууд практикийн үйлчилгээ үзүүлэх боломжтой болдог. АНУ-д нийгмийн ажлыг зохицуулсан угсай хууль байхгүй ч муж бүр өөр өөрийн лицензтэй, нийгмийн ажилтнууд лицензээ хүчинтэй байлгахын тулд тасралтгүй сургалтад хамрагдах шалгууртай өгөөд мэргэжлийн холбоодын үүрэг, үйл ажиллагаа ухал байна (Association of Social Work Boards, 2022). Англид 2017 онд батлагдсан Хүүхэд ба нийгмийн ажлын тухай хуулийн дагуу нийгмийн ажилтнуудыг бүртгэх үйл ажиллагааг зохицуулдаг.

Түүнчлэн нийгмийн ажилтны шалгуурыг хангасан ингэ мэргэжилтнүүдийг чадавхжуулах нэг жилийн өтөлбөрийг мэргэжлийн холбоо нь хэрэгжүүлдэг (Social Work England, 2022; The British Association of Social Workers, 2022). Нидерланд, Израйль улсуудад эн адил нийгмийн ажилтнуудыг бүртгэх эсвэл лицензжүүлэх шалгууртай (Hussein, 2011). Израйль улс 1996 онд Нийгмийн ажлын хуулийг баталсан байдаг өгөөд хуулийн агуулгад мөн л нийгмийн ажилтныг бүртгэх, мэргэжлийн үйлчилгээнд баримтлах зарчим, риуцлага, мэргэжлийн бэлтгэл зэргийг багтаасан

байна (Social workers law, 1996).

Нийгмийн ажилтнуудад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгож байгаа нь тухайн мэргэжлийг хамгаалах гэхээс илүүтэй олон нийтийн эрх, ашгийг хамгаалж байгаа явдал аж (Association of Social Work Boards, 2022). Өөрөөр хэлбэл нийгмийн ажилтнуудын мэдлэг, үр чадварт тавьж буй нийтлэг шаардлага, шалгуур нь үйлчилгээ авч байгаа иргэдийн дээд эрх ашиг, аюулгүй байдлыг хангаж байна. Харин Монгол, Польш болон ОХУ зэрэг хуучин социалист улс орнуудад нийгмийн ажилтны лиценз ба бүртгэл одоогоор байхгүй бөгөөд нийгмийн ажлын үйлчилгээ нь нийгмийн хамгааллын салбарын хуулиар зохицуулагдаж байна. Түүнчлэн нийгмийн ажилтныг Польш улсад дипломын түвшинд буюу 2,5 жилд, Монгол, ОХУ-д ихэвчлэн бакалаврын сургалтаар бэлтгэж байна (Hussein, 2011; Borodkina, 2015; Majewska-galeziak, 1998).

Эндээс харвал эрүүл мэндийн салбарт ажиллах нийгмийн ажилтны мэргэжлийн үйлчилгээг зохицуулсан бодлого эрх зүй болон нийгмийн ажилтнуудад мэргэжлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох эсвэл бүртгэх үйл явц нь эрүүл мэндийн тогтолцооноос үл хамааран ихэнх улс орнуудад хэрэгжиж байна.

### Хэлэлцүүлэг

Энэхүү судалгаагаар бид эрүүл мэндийн салбар дахь нийгмийн ажлын үйлчилгээг улс орнуудын эрүүл мэндийн тогтолцооны онцлогоор харьцуулсан ба ингэхдээ үйлчилгээний санхүүжилт, мэргэжлийн үйлчилгээг хүргэхтэй холбоотой эрх зүйн баримт бичиг, нийгмийн ажилтанд мэргэжлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох үйл явц зэргийг авч үзэв. Судалгааны үр дүнгээс харахад нийгмийн ажлын үйлчилгээг зохицуулсан эрх зүйн баримт бичиг ихэнх улс оронд байгаа ба энэ нь салбар нийгмийн ажилд нэгэн ижил үйлчилж байна. Зарим улсад тусгайлан нийгмийн ажлын тухай хууль байгаа бол зарим улсад нийгмийн хамгааллын салбарын хуульд эрүүл мэндийн нийгмийн ажлын үйлчилгээг багтаан үзжээ.

Ихэнх улс орнуудад энэхүү хууль, эрх зүйн тогтолцоо нь мэргэжилтэн бэлтгэх болон нийгмийн ажилтныг бүртгэх, лицензжүүлэх үйл ажиллагаатай уялдаж байна. Мөн эрүүл мэндийн салбар дахь нийгмийн ажлын үйлчилгээ нь эрүүл мэндийн даатгалаас болон нийгмийн үйлчилгээний хөтөлбөрүүдийн хүрээнд гэсэн

хоёр эх үүсвэрээс санхүүжиж байна.

Харин Монгол улсын хувьд нийгмийн ажлын үйлчилгээ нь зөвхөн үйлчилгээ үзүүлж байгаа нийгмийн ажилтны цалингаар дамжсан нэг эх үүсвэртэй байна. Монгол улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нийгмийн ажлын тухай хуулийн төслийг боловсруулж байгаа бөгөөд зорилгыг нь нийгмийн ажилтнуудын үйл ажиллагааны хариуцлага, ил тод байдал, мэдлэг, ур чадвар, ёс зүйг нэмэгдүүлэх замаар мэргэжлийн нэр хүндийг өсгөх, төрийн зүгээс нэгдсэн удирдлагаар хангах бүтцийг бий болгох гэж томъёолсон байна (ХНХЯ, 2022).

Хуулийн төсөлд нийгмийн ажлын тодорхойлолт, үйлчилгээний төрөл, нийгмийн ажилтнуудыг лицензжүүлэх тухай тодорхой заасан нь давуу талтай. Харин нийгмийн ажилтны цалингийн хэмжээг тогтмол нэмэгдүүлж байхаар тусгасан хэдий ч үйлчилгээний санхүүжилтийг зөвхөн нэг эх үүсвэр хэвээр авч үзсэн нь хязгаарлагдмал байна. Учир нь цалингаар санхүүждэг Польш улсын хувьд нийгмийн ажилтны ачаалал их, нийгэмд мэргэжлийн нэр хүнд бага байгаагаас нийгмийн ажилтнуудад ажил үүргээ гүйцэтгэхэд бэрхшээлтэй байх зэрэг асуудал тулгардаг байна (Balogovb & Pachner, 2021). Харин АНУ, Англи, Израйл зэрэг зах зээлийн мөн төгс иж бүрдэлт тогтолцоотой улс орнуудад санхүүжилтийн эх үүсвэр нэгээс олон байгаагаас гадна нийгмийн ажлын үйлчилгээ нь эрүүл мэндийн тогтолцооны салшгүй нэг хэсэг болон хөгжиж байна.

Манай орны хувьд нийгмийн ажлын үйлчилгээг санхүүжүүлэх эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломж байна. Тухайлбал, 2022 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталсан "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-ийг баталсан нь нийгмийн ажлын үйлчилгээг санхүүжүүлэх сайн туршлага болжээ. Уг тушаалд шуурхай тусламжийн, хамгаалах болон нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх гэсэн гурван төрлийн үйлчилгээг хүчирхийллийн төрөл болон үйлчилгээ үзүүлсэн байршлаас шалтгаалан ялгаатай байдлаар санхүүжүүлэхээр тусгасан байна. Ингэхдээ тохиолдлын тоо, чанарт тулгуурлан санхүүжүүлэх ба санхүүжилтэд нийгмийн ажилтны цалин, бичиг хэрэг, тээврийн зардлаас гадна баримтжуулалт, холбон зуучлах, сургалтын зардал болон үйлчлүүлэгчид үзүүлэх бусад үйлчилгээний зардлууд багтжээ (ХНХЯ сайд, Сангийн сайд, 2022).

Нийгмийн ажилтнууд эрүүл мэндийн үйлчилгээний төрөл, үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын онцлогоос хамааран ялгаатай үйлчилгээг хүн амд үзүүлдэг бөгөөд дэлхий дахинд эрүүл мэнд, зан үйл, сэтгэцийн эрүүл мэндийн салбарт зайлшгүй чухал мэргэжилтний нэгд нийгмийн ажилтнууд тооцогдож байна. Эрүүл мэндийн нийгмийн ажилтнуудын гүйцэтгэдэг зарим үүрэгт эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа хүмүүст эмнэлгээс гаргах төлөвлөлт хийх замаар тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, архаг өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан зэрэг үйлчлүүлэгчид олон мэргэжлийн багаар, нэгдмэл үйлчилгээг төлөвлөн, хэрэгжүүлэхэд оролцох буюу кейс менежментийн үйлчилгээг хүргэх замаар өвчний хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлт болон эмзэг бүлгийн иргэдэд хүрч очих үйлчилгээ үзүүлэх замаар тухайн хүн амыг аливаа өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн

сэргээх зэрэг багтдаг.

Эдгээр болон бусад чухал шаардлагатай үйлчилгээг эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх үйлчилгээнд тусгаж эрүүл мэндийн салбар дахь нийгмийн ажлын үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломж, шийдлийг цаашид судлах нэн шаардлагатай юм. Учир нь нийгмийн ажлын үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр тогтвортой, баталгаатай байх нь үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэх улмаар эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээнд тэр бүр хамрагдаж чаддаггүй олон иргэдийн сайн сайхан байдал хангагдах боломжтой болно.

Энэхүү судалгаа нь цөөн улс орны хүрээнд зөвхөн эрүүл мэндийн тогтолцооны ангиллын дагуу хязгаарлагдмал эх сурвалжаас мэдээллийг цуглуулж харьцуулалтыг хийсэн сүл талтай. Иймд энэ судалгаа цаашид холимог судалгааны аргыг ашиглан олон эх сурвалжийн мэдээллийг ашиглан хийх нь зүйтэй.

## Ном зүй

Монгол хэлээр

- Наранчимэг.Н, Увш.П, Волгин.Н.А. (2009). Нийгмийн бодлого. Улаанбаатар: Удирдлагын академи.
- Түмэннаст.Г. (2017). Нийгмийн ажлын түхэн тойм. Б.Түмэннаст.Г-Д, Нийгмийн ажил (хуудсд. 23-39) Улаанбаатар: МУИС Пресс.
- Тамир.Ч. (2021 оны 05). Монголын нийгмийн ажлын хөтөлбөрүүдийн түүхэн харьцуулан шинжилгээ. Нийгмийн ажил, хуудсд. 23-36.
- ХНХЯ. (2022). Нийгмийн ажлын тухай хуулийн төслийг үзэл баримтлал.
- ХНХЯ сайд, Сангийн сайд. (2022, 01). Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив.
- Энхтүяа.С, Олончимэг.Д, Оюут-Эрдэнэ.Н. (2008) Монгол улс дахь нийгмийн ажлын хөгжлийн Улаанбаатар.

Гадаад хэлээр

- Association of Social Work Boards. (2022). Chapter A short history of social work regulation. <https://www.aswb.org/wp-content/uploads/2021/02/Your-Association-2021.pdf>-ээс Гапрасан
- Balogovb, B., & Pachner, T. M. (2021). Exploring the self-care practices of social workers in Poland. *European Journal of Social Work*, 84-93.
- Bourque, M., & Farrah, J.-S. (2021). Roemer 20 Years Later: When a Classical Health-System Typology Meets Market-Oriented Reforms. *Revue Gouvernance*. <https://doi.org/10.7202/1038889ar>.
- Borodkina, O. (2015). International trends in Russian social work. *European Journal of Social Work*, 63-644.
- DiNitto, D. M. (2011). Financing healthcare: Can Americans be insured? D. M. DiNitto-Д. Социальное благополучие: Политика и публичная политика (хуудсд. 276-32) Allyn & Bacon.
- Gehlert, S., & Browne, T. (2019). Handbook of health and social work. San Francisco : John Wiley & Sons, Inc.
- Hussein, S. (2011). Social Work Qualifications and Regulation in European Economic Area: Final report. Lanford, D., Petiwala, A., & Landers, G. (2021). Aligning

- healthcare, public health and social services: A scoping review of the role of purpose, governance, finance and data. *Health and Social Care in the Community*, 1-16.
- Majewska-galeziak, A. (1998). Educating for social work in Poland—challenges of the transformation period. *European Journal of Social work*, 95-100.
- National Health System. (2022). NHS. <https://www.nhs.uk/>
- National Health Services . (n.d.). Retrieved from <https://www.nhs.uk/>
- Roemer, M. I. (1993). National health systems throughout the world. *Annual Reviews Public Health*, хуудсд. 335-353.
- Social Work England. (2022). Social Work England. <https://www.socialworkengland.org.uk/>
- Social workers law, 1996.
- The British Association of Social Workers. (2022). The British Association of Social Workers. <https://www.basw.co.uk/>
- US Department of Health and Human Services. (2021, December 01). HHS. Retrieved from <https://www.hhs.gov/programs/health-insurance/index.html>